

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/132/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Чингис хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 91913204 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.24 № 189

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.НАМЖИЛНОРОВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн зөрчлүүд бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг баяр наадам, шинэ жил, улс, аймаг, сумын аваргуудын хүндэтгэлийн арга хэмжээ, уулын тахилгад зарцуулсан, баяр наадам, уралдаан тэмцээний зардалд зарцуулсан бэлэн мөнгөний тайланг гаргаагүй, жилийн эцсийн тооллогыг чанаргүй хийж, эд хариуцагчийн тайланд орлого, зарлагын гүйлгээг анхан баримтгүй бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1-р хавсралтын 7.2-т заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,479,423.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 1,224,079.1 мянган төгрөгийг зарцуулж, 255,343.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

232502199

Мөрийн хөтөлбөр, засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулах хэрэгтэй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 330,974.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 9,950.0 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 3,149.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 317,875.4 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 121 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэл 91.8 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	133,537,779.88	197,118,113.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,750,600.00	4,709,900.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,750,600.00	4,709,900.00
3121	Төгрөг	2,750,600.00	4,709,900.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	19,300.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	2,750,600.00	4,690,600.00
33	АВЛАГА	7,573,520.88	13,867,988.88
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	190,260.64	753,170.64
335	Бусад авлага	7,383,260.24	13,114,818.24
3351	Байгууллагаас авах авлага	7,029,924.24	8,011,482.24
3352	Хувь хүмүүсээс авах авлага	353,336.00	5,103,336.00
34	УРЬДЧИЛГАА	9,000,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	9,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	98,813,659.00	133,560,225.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	125,000.00
354	Хангамжийн материал	77,093,007.00	107,039,573.00
35410	Бичиг хэргийн материал	1,922,980.00	2,192,680.00
35420	Аж ахуйн материал	8,945,190.00	8,545,390.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,460,000.00	200,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,135,380.00	3,282,006.00
35450	Барилгын засварын материал	1,218,000.00	7,088,640.00
35460	Хүнсний материал	375,000.00	60,000.00
35470	Бусад хангамжийн материал	61,036,457.00	85,670,857.00
35500	Биологийн хөрөнгө	13,025,000.00	17,700,000.00
35600	Мал амьтад	8,695,652.00	8,695,652.00
36	НӨӨЦИЙН БАРАА	15,400,000.00	44,980,000.00
36300	Тэжээлийн нөөц	15,400,000.00	44,980,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,201,380,814.09	3,916,285,441.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,201,380,814.09	3,916,285,441.15
392	Биет хөрөнгө	3,157,436,814.09	3,872,341,441.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,394,938,459.62	1,796,238,318.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(481,123,185.85)	(567,440,054.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	201,110,975.80	405,696,475.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(86,395,630.00)	(102,298,216.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	203,992,446.31	307,298,996.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	(136,380,143.89)	(166,541,961.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,576,270.87	50,576,270.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49,615,632.07)	(50,681,085.54)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,967,915,836.00	1,967,915,836.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	8,378,264.00	8,378,264.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	116,582,633.00	264,619,199.84
39215	Хуримтлагдсан элэгдэл	(32,543,479.70)	(41,420,602.12)
393	Биет бус хөрөнгө	43,944,000.00	43,944,000.00
39301	Програм хангамж	382,000.00	382,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(382,000.00)	(382,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	43,944,000.00	43,944,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,334,918,593.97	4,113,403,555.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	304,939.67	219,887.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	304,939.67	219,887.67
413	Өглөг	304,939.67	219,887.67
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	87,647.67	96,887.67
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	22,000.00	22,000.00
4136	Бусад өглөг	195,292.00	101,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	94,292.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	101,000.00	101,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,334,613,654.30	4,113,183,667.36
51	Засгийн газрын хувь оролцоо	3,334,613,654.30	4,113,183,667.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	292,461,021.31	292,461,021.31
51101	Өмч: - төрийн	292,461,021.31	292,461,021.31
512	Хуримтлагдсан үр дүн	2,902,695,543.79	3,681,265,556.85
51210	Өмнөх үеийн үр дүн	2,715,582,676.15	2,902,695,543.79
51220	Тайлант үеийн үр дүн	187,112,867.64	778,570,013.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139,457,089.20	139,457,089.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,334,918,593.97	4,113,403,555.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,083,197,090.80	2,230,393,651.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	334,272,378.80	746,921,125.84
120	Нийтлэг татварын бус орлого	334,272,378.80	746,921,125.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	334,272,378.80	746,921,125.84
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,019,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	331,272,378.80	743,901,825.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	748,924,712.00	1,483,472,526.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,715,512.00	4,049,526.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,104,012.00	2,128,076.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,611,500.00	1,921,450.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	744,209,200.00	1,479,423,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	744,209,200.00	1,479,423,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	839,263,136.60	1,451,823,638.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	839,263,136.60	1,451,823,638.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	680,804,178.35	1,147,168,753.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,929,698.99	591,576,926.19
210101	Үндсэн цалин	183,175,805.24	329,029,783.24
210102	Нэмэгдэл	93,418,729.96	195,207,876.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,528,007.45	35,009,062.22
210104	Урамшуулал	19,509,200.00	10,730,330.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,297,956.34	21,599,874.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,632,299.21	72,685,070.41
210201	Тэтгэврийн даатгал	29,308,722.00	49,478,307.23
210202	Тэтгэмжийн даатгал	3,415,705.05	5,914,969.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,701,267.96	2,940,984.73
210204	Ажилгүйдлийн даатгал	650,411.83	2,852,961.92
210205	Эрүүл мэндийн даатгал	6,556,192.37	11,497,847.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,548,400.22	44,359,120.72
210301	Гэрэл, цахилгаан	14,719,812.22	22,632,980.72
210302	Түлш, халаалт	16,828,588.00	21,726,140.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,167,121.32	41,231,671.00
210401	Бичиг хэрэг	3,098,380.00	4,804,720.00
210402	Тээвэр, шатахуун	14,029,141.32	24,539,342.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,386,000.00	3,096,609.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,490,600.00	5,238,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	91,000.00	3,457,000.00
2105	Нормативт зардал	855,500.00	859,000.00
210502	Хоол, хүнс	7,500.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	848,000.00	859,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,629,800.00	20,907,340.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	300,000.00
210604	Урсгал засвар	5,629,800.00	20,607,340.00
2107	Томилт, зочны зардал	11,784,000.00	17,684,000.00
210702	Дотоод албан томилолт	11,784,000.00	17,684,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,328,591.00	155,226,401.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,111,810.00	154,061,508.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,203,550.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	305,879.00	245,379.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	737,000.00
210807	Газрын төлбөр	169,352.00	127,514.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	171,928,767.61	202,639,223.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,544,252.00	60,235,375.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,099,540.00	80,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	128,284,975.61	142,323,848.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,458,958.25	304,654,885.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,100,000.00	49,310,943.18
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	26,512,943.18
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	17,502,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	5,046,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	155,358,958.25	255,343,942.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	155,358,958.25	255,343,942.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	243,933,954.20	778,570,013.06
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	56,821,086.56	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	56,821,086.56	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-56,821,086.56	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	187,112,867.64	778,570,013.06

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	752,614,190.70	1,490,259,526.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,000,000.00	3,019,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,000,000.00	3,019,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	3,019,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,019,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	749,614,190.70	1,487,240,226.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,404,990.70	7,817,226.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,104,012.00	2,128,076.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,300,978.70	5,689,150.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	744,209,200.00	1,479,423,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	744,209,200.00	1,479,423,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	732,913,190.70	1,383,008,176.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	732,913,190.70	1,383,008,176.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	573,454,232.45	1,076,511,840.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,862,189.85	591,567,686.19
210101	Үндсэн цалин	203,080,309.19	320,220,133.87
210102	Нэмэгдэл	76,750,404.10	204,162,347.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,751,282.86	29,355,000.00
210104	Урамшуулал	13,460,335.11	16,230,330.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,819,858.59	21,599,874.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,693,011.38	72,685,070.41
210201	Тэтгэврийн даатгал	29,278,905.68	49,478,307.23
210202	Тэтгэмжийн даатгал	3,447,386.38	5,914,969.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,700,763.15	2,940,984.73
210204	Ажилгүйдлийн даатгал	655,284.69	2,852,961.92
210205	Эрүүл мэндийн даатгал	6,610,671.48	11,497,847.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,938,000.22	44,359,120.72
210301	Гэрэл, цахилгаан	14,719,812.22	22,632,980.72
210302	Түлш, халаалт	16,218,188.00	21,726,140.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,825,080.00	30,706,117.00
210401	Бичиг хэрэг	3,111,600.00	4,078,220.00
210402	Тээвэр, шатахуун	13,342,680.00	20,809,088.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,386,000.00	3,096,609.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,912,800.00	2,626,200.00
2105	Нормативт зардал	347,200.00	756,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	347,200.00	756,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,282,700.00	19,815,840.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,000.00	2,121,000.00
210604	Урсгал засвар	5,257,700.00	17,694,840.00
2107	Томилолт, зочны зардал	11,762,000.00	17,684,000.00
210702	Дотоод албан томилолт	11,762,000.00	17,684,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,077,021.00	235,304,641.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,860,240.00	234,139,748.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,203,550.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	305,879.00	245,379.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	737,000.00
210807	Газрын төлбөр	169,352.00	127,514.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,667,030.00	63,633,365.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,622,510.00	63,553,365.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,044,520.00	80,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	159,458,958.25	306,496,335.58

2132	Бусад урсгал шилжүүлэг	3,100,000.00	49,310,943.18
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	26,512,943.18
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	17,502,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	5,046,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	156,358,958.25	257,185,392.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	156,358,958.25	257,185,392.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,701,000.00</u>	<u>107,251,350.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,601,000.00	105,292,050.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,601,000.00	105,292,050.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,601,000.00	105,292,050.00
223001	Бусад хөрөнгө	17,601,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		105,292,050.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(17,601,000.00)</u>	<u>(105,292,050.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,100,000.00	1,959,300.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,750,600.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,750,600.00	4,709,900.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	2,715,582,676.15		3,147,500,786.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	2,715,582,676.15	-	3,147,500,786.66
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	187,112,867.64		187,112,867.64
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	2,902,695,543.79		3,334,613,654.30
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	2,902,695,543.79		3,334,613,654.30
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	2,902,695,543.79	-	3,334,613,654.30
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	778,570,013.06		778,570,013.06
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	292,461,021.31	139,457,089.20	3,681,265,556.85		4,113,183,667.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,479,423,000.00	1,224,079,057.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,479,423,000.00	1,224,079,057.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,431,554,800.00	1,177,278,114.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	753,912,700.00	591,567,686.19
210101	Үндсэн цалин	323,079,900.00	329,020,543.24
210102	Нэмэгдэл	290,233,600.00	195,207,876.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,150,000.00	35,009,062.22
210104	Урамшуулал	-	10,730,330.00
210105	Гэрээт ажлын хөлс	74,449,200.00	21,599,874.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,238,400.00	72,685,070.41
210201	Тэтгэврийн даатгал	64,081,800.00	49,478,307.23
210202	Тэтгэмжийн даатгал	7,539,100.00	5,914,969.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,769,600.00	2,940,984.73
210204	Ажилгүйдлийн даатгал	3,769,600.00	2,852,961.92
210205	Эрүүл мэндийн даатгал	15,078,300.00	11,497,847.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,035,200.00	44,199,120.72
210301	Гэрэл, цахилгаан	26,838,800.00	22,632,980.72
210302	Түлш, халаалт	22,396,400.00	21,566,140.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	37,944,500.00	30,706,117.00
210401	Бичиг хэрэг	5,614,200.00	4,148,220.00
210402	Тээвэр, шатахуун	23,000,000.00	20,809,088.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,478,200.00	3,096,609.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,045,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,807,100.00	2,556,200.00
2105	Нормативт зардал	1,807,100.00	756,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807,100.00	756,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,656,000.00	37,172,390.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,812,900.00	19,477,550.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943,100.00	00.00
210604	Урсгал засвар	17,900,000.00	17,694,840.00
2107	Томилолт, зочны зардал	30,000,000.00	17,684,000.00
210702	Дотоод албан томилолт	30,000,000.00	17,684,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	342,863,100.00	321,642,065.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	338,740,100.00	320,477,172.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	622,800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,014,300.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536,400.00	245,379.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,600.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740,400.00	737,000.00
210807	Газрын төлбөр	963,500.00	127,514.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,097,800.00	60,865,665.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,548,900.00	60,785,665.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,548,900.00	80,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,868,200.00	46,800,943.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,868,200.00	46,800,943.18
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,032,600.00	250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,752,100.00	26,512,943.18
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,502,000.00	17,502,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,581,500.00	2,536,000.00
1320	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,479,423,000.00	1,482,423,000.00
132001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,479,423,000.00	1,479,423,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,479,423,000.00	1,479,423,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	3,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,000,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,049,526.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,049,526.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,758,076.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,000.00
210302	Түлш, халаалт	160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,298,076.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,298,076.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,450,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,841,450.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,841,450.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,049,526.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,049,526.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,128,076.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,921,450.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,950.0 мянган төгрөгийн төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Үүнд:

Нөөцийн бараанаас зарлагадсан 5,200.0 мянган төгрөгийн хивэг, ногоон тэжээлийг цалингийн зардалд бүртгэснийг бараа материалын зохих зардалд бүртгэж залруулав.

Тайлант оны эцэст Цэнэ трейд ХХК-д төлсөн 4,750.0 мянган төгрөгийн засварын материалыг бодитоор хүлээн аваагүй дэлгэрэнгүй тайлангаар зарлагадсан гүйлгээг залруулж, урьдчилж төлсөн зардлаар бүртгэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 321,024.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,149.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 317,875.4 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.1 Төлбөрийн акт

МУ-ын Эрчим хүчний сайдын 2021 оны А/129 тоот тушаалаар батлагдсан "Халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох тухай" тушаалын "В"-д заасан хугацааг баримтлаагүй гэрээ байгуулж 1,399.1 мянган төгрөг илүү төлсөн.

3.2 Албан шаардлага

Засаг даргын нөөц сангаас баяр наадам, шинэ жил, улс, аймаг, сумын аваргуудад хүндэтгэлийн арга хэмжээ, уулын тахилгат 6,219.2 мянган төгрөг зарцуулж, зарцуулалтын тайланг гаргаагүй нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5-д "энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ"-г санхүүжүүлэхэд зарцуулна гэснийг зөрчсөн байна.

Баяр наадам, уралдаан тэмцээний зардалд бэлнээр зарцуулсан 5,350.0 мянган төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримтгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 7.2-т "Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна." гэснийг мөрдөөгүй.

Бараа материалын жилийн эцсийн тооллогоор 675.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, бэлэн бүтээгдэхүүнийг тоолоогүй, 116,983.9 мянган төгрөг орлого, 59,675.1 мянган төгрөг зарлагын баримтгүй бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.1-т "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах"

3.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Жич: Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн зөрчлийг тайлангийн 4.3, 4.4-өөс харна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цалингийн зардалд бараа материал зарлагдсан	1	5,200.0			1	5,200.0	1	5,200.0				
Бараа материалыг шууд зарлагдсан	1	4,750.0			1	4,750.0	1	4,750.0				
Дүн	2	9,950.0			2	9,950.0	2	9,950.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Наадмын зардал хэтрүүлсэн	1	5,350.0			1	5,350.0						
ЗДНС-аас зориулалт бус зарцуулсан	1	6,219.2			1	6,219.2						
Халаалтын зардал хэтрүүлсэн	1	1,399.1	1	1,399.1								
Бараа материал	1	177,334.0			1	177,334.0						
Дүн	4	190,302.3	1	1,399.1	3	188,903.2						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Худалдан авалтын тендер зарлаагүй	1	112,502.2			1	112,502.2						
Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан	1	16,470.0			1	16,470.0						
Мөнгөн урамшууллаас татвар суутгаагүй	1	1,750.2	1	1,750.2								
Дүн	3	130,722.4	1	1,750.2	2	128,972.2						
Нийт дүн	3	130,722.4	1	1,750.2	2	128,972.2						



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 78-ХЭА-2025/132/НА-СТА-ТШЗ
А 2370448 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулаан нийлүүлэгч "Өв менежмент" ХХК-д халаалтын улирал эхлэх, дуусах огноог баримтлахгүйгээр 1,399.0 мянган төгрөгийг түлш халаалтын зардлаас илүү төлсөн байна.

Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д "халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох", Эрчим хүчний сайдын 2021.07.22-ны А/129 тоот тушаалаар батлагдсан "Халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох тухай"-ын "В"-д "... Хэнтий ... аймгуудын төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаанаар хангагддаг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууцны халаалтын эхлэх хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр, бусад аж ахуйн нэгж байгууллагуудын халаалтын эхлэх хугацааг 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 01-ний өдрөөр" тогтоосныг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Түлш халаалтын зардлаас илүү зарцуулсан 1,399.1 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Намжилноров, нягтлан бодогч Б.Нандин-Эрдэнэ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА

232505076



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 73-ХЭА-2025/132/НА-СТА-ТШЗ
А2370448 Чингис хот

Г Төлбөр барагдуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн захиргааны албан хаагчдад олгосон 17,502.0, мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас ХХОАТ-ыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1."энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй;" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй татварын 1,750.2 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Намжилноров, нягтлан бодогч Б.Нандин-Эрдэнэ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА

232505073



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 21

Дугаар 88-ХЭА-2025/132/НА-СТА-ТШЗ Чингис хот
А 2370448

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын жилийн эцсийн тооллогоор 675.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, бэлэн бүтээгдэхүүнийг тоолоогүй, эд хариуцагчийн тайланд анхан шатны баримтгүй 116,983.9 мянган төгрөгийн орлого, 59,675.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг бүртгэж, нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.1-т "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор баталгаажуулаагүй" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу хөтөлдөггүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын ЗДТГ-ын дарга Н.Намжилноров, нягтлан бодогч Б.Нандин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА

232504088



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 105-ХЭА/2025/132/НА-СТА-ТШС
А 2370448 Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөрийн хөтөлбөрийн зардлаас төрийн бус байгууллага, 11 иргэнд бөх, сагсан бөмбөг болон уралдаан тэмцээн, цэнгүүний үйл ажиллагаа, бэлэгт 16,470.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.14-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын ЗДТГ-ын дарга Н.Намжилноров, нягтлан бодогч Б.Нандин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА

23250410*



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 106-ХЗА-2025/132/НА-СТА-ТШЗ
А 2370448 Чингис хот

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засаг даргын нөөц сангаас баяр наадам, шинэ жил, улс, аймаг, сумын аваргуудад хүндэтгэлийн арга хэмжээ, уулын тахилгат 6,219.2 мянган төгрөг зарцуулж, зарцуулалтын тайланг гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5-д "энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ"-г санхүүжүүлэхэд зориулна гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын ЗДТГ-ын дарга Н.Намжилноров, нягтлан бодогч Б.Нандин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА



232504100



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 107-ХЭА-2025/132/НА-СТА-ТШЗ
А 2370448

Чингис хот

Г Зөрчлийг таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баяр наадам, уралдаан тэмцээний зардалд бэлнээр зарцуулсан 5,350.0 мянган төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримтгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 7.2-т "Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна." гэснийг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Бэлэн мөнгөний тайланг зохих журмын дагуу гаргаж, тайлагнадаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Намжилноров, нягтлан бодогч Б.Нандин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 108-ХЭА-2025/132/НА-СТА-ТШЗ
А2370448 Чингис хот

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөрийн хөтөлбөрийн зардлаас сумын 100 жилийн ойн зардлын 40.0 сая төгрөг, наадмын талбайн засварын зардлын 45.0 сая төгрөг, ланд крүйзэр 200 машины моторын үнэ 27.5 сая төгрөгийг худалдан авах ажиллагааны тендер зарлаж, сонгон шалгаруулалт хийгээгүй шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт өртгийн дээд хязгаарыг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.1.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Худалдан авах ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын дарга Н.Намжилноров, нягтлан бодогч Б.Нандин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА